



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/15/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112 Цахим хуудас: www.audit.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Ахлах аудитор: Н.Туяа Утас: 99799709
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
Байгууллагын үйл ажиллагаа	9
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.2.1 Залруулсан алдаа	13
4.2.2 Албан шаардлага	13
4.2.3 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
6. Албан шаардлага	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.22 № 268
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол аймгийн Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд анх батлагдсан зорилтот түвшнийг хангаагүй, 71.0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, 71.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3/ "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалт, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	1,179,509.9
1.1.6	Бараа материал	0.0	1,321.0
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.0	872,124.7
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	0.0	2,052,955.6
1.2.1	Үндсэн хөрөнгө	0.0	21,186.0
1.2.2	Биет бус хөрөнгө	0.0	309.2
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0.0	21,495.2
1.3	Нийт хөрөнгийн дүн	0.0	2,074,450.8
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.0	295,418.5
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.0	295,418.5
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0.0	295,418.5
2.3	Өмч	0.0	1,850,000.0
2.3.1	-төрийн	0.0	1,850,000.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	0.0	-70,967.7
2.3.11	Эздийн өмчийн дүн	0.0	1,779,032.3
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	0.0	2,074,450.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	0.0	0.0
2	Борлуулалтын өртөг	0.0	0.0
3	Нийт ашиг (алдагдал)	0.0	0.0
8	Бусад орлого	0.0	70.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.0	70,968.0
12	Бусад зардал	0.0	69.7
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.0	0.0
17	Бусад ашиг (алдагдал)	0.0	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0.0	-70,967.7
19	Орлогын татварын зардал	0.0	0.0
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	0.0	-70,967.7
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	-70,967.7
24	Орлогын нийт дүн	0.0	-70,967.7
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.0	0.0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	1,850,000.0	0.0	0.0	0.0	1,850,000.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	2021 оны 04-р сарын 31-ны үлдэгдэл	1,850,000.0	0.0	0.0	0.0	1,850,000.0
2	Залруулсан үлдэгдэл	1,850,000.0	0.0	0.0	0.0	1,850,000.0
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	-70,967.7	-70,967.7
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,850,000.0	0.0	0.0	-70,967.7	1,779,032.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.0	0.0
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.0	0.0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.0	0.0
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.0	0.0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.0	0.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.0	0.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	69,811.9
1.2.1	Ажиллагчдад төлсөн	0.0	30,278.0
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.0	8,735.8
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.0	5,181.9
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.0	3,140.0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.0	6,374.0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.0	0.0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	0.0	2,557.3
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.0	0.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	0.0	13,544.9
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	-69,811.9
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
2.1	Мөнгөн орлогын дүн	0.0	295,488.5
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.0	0.0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.0	295,418.5
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.0	0.0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.0	0.0
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.0	0.0
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	896,166.7
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	23,692.0
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	350.0
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.0	872,124.7
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	-600,678.2
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
3.1	Мөнгөн орлогын дүн	0.0	1,850,000.0

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	1,850,000.0
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.0	0.0
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	0.0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.0	0.0
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.0	0.0
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.0	0.0
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.0	0.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	1,850,000.0
4	Валютын ханшийн зөрүү	0.0	0.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	1,179,509.9
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.0	0.0
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.0	1,179,509.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон сууц ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг “Хэнтий аймгийн ард иргэдийн хямд үнэтэй чанартай орон сууцаар хангах, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авахад дотоод аудит хийгдээгүй тул аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аудитын код: ХЭА-2022/15/НА-СТА- ОНӨААТҮГ

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 71.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Орон сууц ОНӨААТҮГ-ын зорилго нь “Аймгийн хэмжээнд иргэдийг орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх, бага дунд орлоготой иргэд, төрийн албан хаагчдыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, түрээсийн орон сууцанд хамруулах, хөнгөлөлтийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж заажээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг :

1. Аймгийн хэмжээнд иргэдийг орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх, бага дунд орлоготой иргэд, төрийн албан хаагчдыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, түрээсийн орон сууцанд хамруулах, хөнгөлөлтийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлнэ.
2. Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр татах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулах замаар хөрөнгийн тогтвортой сан бүрдүүлж, барилгын хөрөнгө оруулалт, зээл санхүүжилтийг цогцоор нь шийдвэрлэх.
3. Аймгийн нутаг дэвсгэрт орон сууц бариулах ажлыг зохион байгуулах
4. Үйлдвэрийн газрын барьсан болон захиалан бариулсан орон сууцны хотхон, хорооллын барилга, байгууламж, талбайг түрээслүүлэх, худалдан борлуулах, гэрээний биелэлтийг хангуулах
5. Тусгай зөвшөөрөлтэй гадаад, дотоодын компани, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран орон сууц, үл хөдлөх хөрөнгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
6. Залуу гэр бүл болон төрийн албан хаагчдад чиглэсэн орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урт хугацааны , хямд түрээсийн орон сууцны менежментийг хэрэгжүүлэх
7. Аймгийн төв болон сумдад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах гэрэгээр хэрэгжүүлэх
8. Хувийн хэвшлийн хөрөнгөөр барьсан орон сууцны тодорхой хэсгийг худалдан авах
9. Үндсэн зорилтод нийцсэн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно гэж заажээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Орон сууц ОНӨААТҮГ -ыг аймгийн йргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 31-ний 23 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлийн 77.2.4 “2. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих. 4. Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.” гэсэн заалттай нийцэж байна.

ОНӨААТҮГ-ын удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтсийн дарга, СТСХ-ийн дарга, ХОХБТХ-ийн дарга, СТХС-ийн орлогын мэргэжилтэн, ОНӨГ-ын дарга, ТББ-ын төлөөлөл, иргэний төлөөллийн бүрэлдэхүүнтэй томилж байгаа нь ТБОНӨТХ-ийн 21 зүйлийн 5. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлж оролцох гишүүдийг томилохдоо дараах болзлыг хангасан нэр дэвшигчдээс томилно: 1/тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай; 2/тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх; 3/төрийн захиргааны албан хаагч болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээдийн ажилтан байх” заалттай нийцэж байна

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх.”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 6 орон тоогоор ажиллаж, үйл ажиллагааны зардлыг 17.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсвийн хүрээнд 9500.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1297.4 мянган төгрөгийн ажлын дүрэмт хувцас худалдан авсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Орон сууц ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Аудитын код: ХЭА-2022/15/НА-СТА- ОНӨААТҮГ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,179,509.9	1,179,509.9
Авлага			-
Бараа материал		1,321.0	1,321.0
Урьдчилж төлсөн зардал		872,124.7	872,124.7
Үндсэн хөрөнгө		21,186.0	21,186.0
Биет бус хөрөнгө		309.2	309.2
Нийт хөрөнгө	-	2,074,450.8	2,074,450.8
Өр төлбөр	-	-	-
Урьдчилж орсон орлого		295,418.5	295,418.5
Урт хугацаат өглөг			-
Эздийн өмч /төрийн/		1,850,000.0	1,850,000.0
Хуримтлагдсан ашиг		-70,967.7	-70,967.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	2,074,450.8	2,074,450.8

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 5.0 сая төгрөгийн үлдэгдэл байна. Банк дахь харилцах дансанд байгаа 1,174.6 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаас, ХААН банк дахь үйл ажиллагааны харилцах дансанд 12.1 сая төгрөгийн, Төрийн банк дахь хөрөнгө оруулалтын арга хэмжээний харилцах дансанд 866.9 сая төгрөгийн, орлого төвлөрүүлэх ХААН банк дахь харилцах данс 268.2 сая төгрөгийн, Төрийн банк дахь харилцах данс 8.5 сая төгрөгийн, Хас банк дахь харилцах данс 18.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урьдчилж төлсөн зардал дансанд тайлант онд гүйцэтгэгч Алсын солонго ХХК-д барилгын ажлын гүйцэтгэлийн гэрээний төлбөрт 813.8.1 сая төгрөгийн, Анга транс ХХК-д 60 айлын орон сууцны зураг төсвийн үнэд 58.3 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлж бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд 11.4 сая төгрөгийн худалдан авалт хийж, 10.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 1.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансанд 23.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 2.5 сая төгрөгийн элэгдэл тооцон, үлдэгдэл 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Биет бус хөрөнгөд 0.3 сая төгрөгийн барилгын төсвийн программ хангамжийг орлого авсан байна.

Урьдчилж орсон орлого дансанд орон сууцны борлуулалтын урьдчилгааны орлого 295.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 31-ний 23 дугаар тогтоолоор Орон сууц ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулахдаа дүрмийн санг 1,850.0 сая төгрөг байхаар тогтоон, орон нутгийн төсвөөс 1,850.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Орон сууц ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 19-ны 01 дүгээр тогтоолоор Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны борлуулалтын

орлогыг 2,004.7 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 1739.0 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 111.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,889.3 сая төгрөгөөр, 115.4 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 22-ны 3 дугаар тогтоолоор Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг хөрөнгө оруулалтын зардлыг 872.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 111.0 сая төгрөгөөр, тайлант онд борлуулалтын орлогогүй байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 0.07 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 71.0 сая төгрөгийн зардал гарган, 71.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тайлант онд орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах гэрээт ажил дуусаагүй, борлуулалт хийгээгүй нь нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 93.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 17.1 сая төгрөг буюу 15.5 хувиар хэмнэсэн нь үйл ажиллагааны бусад зардлуудыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 872.1 сая төгрөгийг өөрийн эх үүсвэрээс 872.1 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 71.0 сая төгрөг болсон нь үйл ажиллагааны зардлын алдагдал бөгөөд орон сууцны барилгын гэрээт ажлыг хугацаанд нь дуусгаагүйтэй холбоотой байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хэнтий аймгийн Орон сууц ОНӨААТҮГ нь Хэрлэн сумын Шинэ Өндөрхаан хорооллын 30 айлын 2, 60 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг 3,320.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Алсын солонго ХХК-тай гэрээ байгуулсан байна. Гэрээний нийт дүн 3,320.0 сая төгрөг. Үүнээс 2021 онд 2,260.0 сая төгрөг, 2022 онд 1,060.0 сая төгрөг

Магадлалаар баталгаажсан зургийг захиалагч хүлээн авч барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрөл өгснөөс хойш 2021 оны 12 дугаар сарын 25-нд эхний 30 айлын орон сууцны барилгыг, 2022 оны 08 дугаар сарын 01-нд дараагийн 30 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэн комисст хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч 2021 онд Алсын солонго ХХК-д ажлын гүйцэтгэлээр 872.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, Алсын солонго ХХК барилгын гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих нийт мэдээлбэл зохих 3,543.2 сая төгрөгийн 19 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Орон сууц ОНӨААТҮГ 2021 онд шинээр үүсгэн байгуулагдсан тул өмнөх онд аудит хийгээгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар зорилтот түвшнийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг анхаарч үзэхээр тооцов.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 79.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 71.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.2.1 Залруулсан алдаа

Цалингийн зардлыг журнал, анхан шатны баримттай тулгахад мөнгөн гүйлгээний тайланд 6,740.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

4.2.2 Албан шаардлага

Байгууллагын дансанд бүртгэлгүй автомашинд 1,514.0 мянган төгрөгийн сэлбэг худалдан авч үр ашиггүй зардал гаргасан байна.

4.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- 1 Төсвийн хөрөнгийн үр ашигтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд анх баталсан зорилтот түвшнийг хангаагүй, 71.0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, 71.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3/ "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалт, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, зорилтот түвшнийг үр ашигтай байхаар төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Орон сууц ОНӨААТҮГ	3	79.2	1	6.7			1	1.5	1	71.0
Дүн		3	79.2	1	6.7			1	1.5	1	71.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Орон сууц ОНӨААТҮГ										
Дүн											
Нийт дүн		3	79.2	1	6.7			1	1.5	1	71.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 182/А2370447
ХТЭ 2022/15/НАСТА-ШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Орон сууц ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дансанд бүртгэлгүй автомашинд 1,514.0 мянган төгрөгийн сэлбэг худалдан авч үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4 "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтад нийцээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болох бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон сууц ОНӨААТҮГ-ын захирал Д.Баттулга, нягтлан бодогч Э.Даваажав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297
СIOA0046 0074082